

Орон бүсийн пролетар нар нэгдэвч!

АНХ ДЭГДЭЭР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ

№ 75 (2379)

1974 оны 10 дугаар сарын 7

ДАВАА

МАЛЫН ТАРГА ТОГТООЛТ

МАН-н үйлдвэрлэлийн олон талт ажлын нэг нь мал сүргийг зун намрын улиралд оторлон таргалуулж, тарга хүчийг нь улам чамбайруулан тогтоох явдал мөн.

Энэ жил нилээд сумдад гандуу байсан, мөн цас эрт орж байгаа нь малын тарга хүч тогтоох ажлыг хариуцлагыг улам нэмэгдүүлж байна. Өнгөрсөн жил манай аймгийн хөдөлмөрчид мал сүргээ отроор таргалуулж авсан тарга хүчийг нь тогтооход онцгой анхаарч ажилласнаар өнгөрсөн оны мөн үеийнхээс 80,9 мянган төл нлүү бойжуулж, малын зүй бүс хорогдол 16,5 мянгаар, хээл хаялт сувайралт 15,2 мянгаар багасав. Энэ бол малын тарга хүчийг тогтоох талаар чармайлттай ажилласны үр дүн юм.

Зун намрын цагт тарга хүч сайн авсан мал өвөл хаврын хатууг ажралгүй давж онд сайн ордог нь тэргүүний малчдын туршлагаас харагдаж байна. Тэргүүний малчдын туршлага судалгаа шинжилгээний дүнгээс үзэхэд бэлчээрээр оторлон таргалуулж, авсан тарга хүчийг тогтоох ажлыг сайн хийхэд нас гүйцсэн малын жин 30—50 хувь, өсвөрийн малынх 60—70 хувь хүртэл нэмэгддэг байна. Гэтэл хариуцсан малаас ус, бэлчээр, хужрын сайныг дагуулан оторлож олсон тарга хүчийг нь чамбайруулан тогтооход базаалтай анхаардаггүй явдал байна. Намар оройтох тутам өвс ургамал гандан түүний шимт чанар багасдаг. Бэлчээрийн ургамлын нөөц 12, 1-р сард, 7-р сард байснаасаа 2,5—3,0 дахин буурдгийн дээр 4—12 см зузаан цасан бүрхүүлд хучигдсан учраас бэлчээрийн ургамлын бүх нөөцийн 40—60 хувийг ашиглаж чадахгүйд хүрдэг байна. Ийм үед мал сүргийн шаардлагатай тэжээлийг бэлчээрээр хангах боломжгүй болж нэмэгдэл тэжээлээр тэжээх хэрэгтэй болно.

Тиймээс малын тарга хүчийг алдагдуулахгүйн тулд тэжээл, байр, хэвтрийн хангалттай нөхцөлд маллаг малын үргүй ивалтыг хязгаарлаж гишгээд идэшлэлийг нь тохируулан аль болохоор цагтаж өлдүүлэхгүй байхад анхаарлаа хандуулж ялангуяа хээлтэй малын хээл томрох тутам шин тэжээлт бодис их хэмжээгээр шаардагдах учир хэвийн тарга хүчтэй байлгах хэрэгтэй. Намар цагийн малыг аль болохоор хөлөргөхгүй байвал зохино. Сөл муудаж эхэлмэгц нам доор газрын амтлаг ургамлуудыг сорчлон идүүлж, оройтож хэнээлдэг газрыг дагуулан хариуцал аль болохоор задгай хотлуулж хүйтэнд дасгасаар өвөлжөөлөхдөө бэлчээрийг алсаас нь эхлэн идүүлж бэлчээрээ хямгатай ашиглах ёстой. Малчин бүр малын тарга хүчийг тогтооход онц анхаарч 11-р сарын дунд үе хүртэл малаа таргалуулж хүчийг нь тогтоож чадвал өвлийг өктэй өнгөрүүлэх боломж байна. Малыг өвлийн цагт ая тааваар нь явуулж гишгээд идэшлэлийг нь тохируулан хариуцахгүй, ширүүн хөөж туух, гуужалга олон удаа гатлуулахад хөлөрч хөдс нь ноосондоо шингэн цан хүүрэг болж битүү жиндэж даарснаас тарга хүчээ алдах нь амархан болдог. Өвөлжөөндөө буумагц хашаагаа тавиу болгож эхний үед задгай хотлуулж хүйтрэх үед хашаагаа малаа тохируулан багасгавал мал даарч зуграх нь бага байдаг.

Ер нь өдөр нь сайн цадсан мал шөнө даардаггүйн дээр намрын сүүлч, өвлийн эхэн үеэр хонийг хавирганаас нь өвлийн дунд ба сүүлчээр хэвтрээс нь дааруулахгүй байвал тарга хүчээ сайн тогтоодгийг санаж ажиллах нь чухал. Малд тарга хүчийг тогтоохын тулд 3—5 хоногт хужирлаж, өдөр бүр тогтмол хугацаанд усалж байвал тарга нь чамбайрдаг. Хужрыг өвлийн улиралд дангаар нь буюу бусад тэжээл, устай хольж тогтмол өгч байх нь мал даарч тарга хүчээ алдахаас хамгаална. Малын тарга хүчийг тогтоох ажлын ач холбогдлыг малчдад сайтар таниулж, малаа онд тарган оруулдаг тэргүүний малчдын туршлагыг нийтийн хүртээл болгох, малчдын дунд социалист уралдаан өрнүүлж явцад тавих хяналт шалгалтыг сайжруулах явдал орон нутгийн нам, улс, аж ахуйн байгууллагын чухал зорилт болж байна.

ГЭРЭЛ ЗУРГИЙН ҮЗЭСГЭЛЭН

Монгол—Зөвлөлтийн уламжлалт найрамдлын 23 дахь сарын ажлыг тохиолдуулан аймгийн МЗНН-ийн зөвлөлөөс эрхлэн Зөвлөлт Казакстаны хагас зуун жилийн ой, мөн атар газар эзэмшсэний 20 жилийн ойд зориулсан гэрэл зургийн үзэсгэлэн аймгийн Соёлын ордонд нээж ажилдуулав.

Үзэсгэлэнд Кызыл-Куйн говь усжуулалт, Лениний нэрэмжит Гурьевскийн нефтийн завод, Павлодарск хотын тракторын заводын үйл ажиллагааг дэлгэрэнгүй харуулсан олон гэрэл зураг тавигджээ. Гэрэл зургийн эд үзэсгэлэн Зуунмод хотын хөдөлмөрчид үргэлжлэн үзсээр байна.

ЗХУ-д

ЗХУ-ын үр тарианы аж ахуйд сүүлийн жилүүдэд үлэмжийн ахиц гарчээ.

1971—1973 онд үр тарианы жилийн дундаж үйлдвэрлэл 190,6 сая тонн болсон байна.

Зөвхөн 1973 онд улсын хэмжээгээр 222,5 сая тонн үр тариа хураажээ.

ЗХУ-ын үр тарианы талбай Франц, Их Британи, ХБНГУ, Италийн бүх нутгийг нийлүүлсний дaitай аж.

НАМЫН ГИШҮҮНИЙ МАНЛАЙЛАЛ

ТЭРГҮҮНИЙ БРИГАДЫН НЭГ

1968 оны 8-р сар. Хар тэрлэг өмсөж шар дурдан бүс бүсэлсэн 50 орчим насны эр, хонгор халзан морь унаж Заамар сумын төвөөс баруун хойш Ухаагийн бригадыг чиглэн хатируулж явав. Энэ хүн намын уриалгаар сумынхаа төвөөс бригадын даргаар ажиллахаар очиж байгаа Балжидын Дагвадорж байлаа.

Тэр намраа саалийн бригадынхны хүчээр конторын барилга, халуун ус, ухуулах байр барьж тохижуулав. Энэ үеэс эхлэж хамтын хөдөлмөрийн үзэл санаа, хүч тус бригадынхныг нэгтгэжээ. Дагвадорж хийх ажлаа дэс дараатай төлөвлөж социалист уралдаан өрнүүлэн ажилласнаар тэр намраа улсад тушаах сүүний төлөвлөгөөг 9 дүгээр сарын 10-нд 110 хувиар биелүүлжээ. Үхэр сүргээ эр сувайгаар нь 20 суурь болгон хүн бүлийн хүчинд

зохицуулан өгч бухыг тусд нь суурилан хээлтүүлгийн үед үнээс бухны тохироог нарийн баримталж үхэр сүргийг хавраас эхлэн өвөлжөөлд ортол оторлодог болов. Мөн үхэр сүрэгтээ жилд 2 удаа үзлэг хийж өвчтэйг ялаган суурилж эмчлүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг явуулжээ.

Үүний үр дүнд V таван жилийн төлөвлөгөөг 2 жилийн өмнө 187 үхрээр давуулан олоо 7280 үхэртэй, 33 суурьтай боллоо. Үхрийн боловсон байр 32-той болж сумын энх сүрэгтэн Ш. Дагва, Нацагдорж, сумын саалийн 6 удаагийн аварга саальчин Нацаг нарын зэрэг тэргүүний хүмүүс тус бригадаас төржээ.

1974 онд зуун үнээнээс 60 тугал бойжуулж хөөврийн төлөвлөгөөг 120 хувиар биелүүлж улсад 368 тонн мах, 200 000 литр сүү тушааж сай-

хан амжилт гаргав. Энэ бригад өвлийн бэлтгэлийг зунаас эхлэн хийдэг заншилтай бөгөөд өнөө жил 32 хашааныхаа 26-г засварлан сэлбэж үхэрчдийнхээ хүчээр 850 тонн байгалийн хадлан бэлдэж өвөлжөөндөө татаж байна. Тус бригад малчдын дундад уралдааныг шинэ шатанд хүргэсн чуулга уулзалт, 1000 халзан үнээний баяр гэсэн болзолт уралдаануудыг өрнүүлэн бригадын өдөрлөгийг тогтмолжуулж намын ухуулын ажлыг цаг үеийн ажилтай холбон зохиож байна. Дагвадорж гуайн үсэнд буурал орж нас нь 60 хүрч яваа ч гэсэн ажлынхаа амжилтанд улам зоригжин хийж бүтээе гэсэн хүслээрээ жигүүр хийн хонгор халзан морно унасаар 33 суурийнхаа дунд Ар урт, Эрэн хавирга, Тосон, Ухаагийн хөндийгөөр хатируулсаар явна.

Ш. Бямба

Социалист УРАЛДААН

ШАГНАЛ ГАРДУУЛАВ

Монгол—Зөвлөлтийн боловсруулах Үйлдвэрийн уламжлалт найрамдлын 23 ажилчдын ҮЭ-ийн Төв Ходахь сарын ажлын нээл-рооны нарийн бичгийн дартийг тохиолдуулан улсын га Шагдарсүрэн гардуу-аварга бригадын болзол лав. Мөн хурал дээр V хангасан аймгийн Барилга таван жилийн төлөвлөгөөг угсралтын конторын биелүүлсэн НААУ-ний газ-Д. Намсрай даргатай нэгд-рэн ажилчин А. Должин-сэн бригадад улсын сүрэн, Б. Хишигхүү, Барилга аварга бригадын пол, дип- угсралтын конторын ба-лом, мөнгөн шагнал, мөн рилгачин Г. Бор, Холбоо- V таван жилийн төлөвлө- ны газрын шуудан тасгийн гөөг хугацаанаас нь өмнө ялгач Ш. Цэрэнханд, биелүүлсэн гавшгайцад УААУ газрын жолооч «V таван жилийн гавшгайч Л. Гончигсүрэн нарын 20 тэмдэг», мандат олгох ху- гаруй хүнд «V таван жи-рал саяхан болов. Хурлыг лийн гавшгайч тэмдэг, ман- аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн дат, шагнал олгов.

нарийн бичгийн дарга Шагнагдагсдыг төлөөлж П. Очирбат нээж, улсын аварга бригадын а в а р г а бригад болсон дарга Д. Намсрай, НААУ- онд улсын аварга бри- гадын пол, диплом, 5500 Ш. Дарьсүрэн нар үг хэлж, төгрөгийг Барилга Ой Мод үүрэг авав.

БАЯРЫН ХУРАЛ

Монгол—Зөвлөлтийн лийг, аймгийн АДХ-ын уламжлалт найрамдлын 23 гүйцэтгэх захиргааны ха- дахь сарын ажлын нээлтэд риуцлагатай нарийн би- зориулсан Зуунмод хотын гийн дарга, МЗНН-ийн ай- нам, улс, олон нийтийн бай- гийн зөвлөлийн орлогч гууллага, хөдөлмөрчдийн дарга Г. Шарав хийв. төлөөлөгчдийн баярын Дараа нь тус аймагт хурал, аймгийн соёлын ор ажиллаж байгаа Зөвлө- долд энэ сарын 4-нд бол тийн мэргэжилтнүүдийг тө- лоо. Баярын хурлыг айм төлөөлж, аймгийн төвийн 10 гийн Намын хорооны на- жилийн дунд сургуулийн рийн бичгийн дарга, МЗНН- багш З. В. Цвектова баяр ийн аймгийн зөвлөлийн дар хүргэж үг хэлэв.

га Х. Билгээ нээж, Мон- Хурлын дараа Монгол- гол—Зөвлөлтийн найрамд- Зөвлөлтийн уламжлалт- лын 23 дахь сарын ажлын найрамдлыг харуулсан ки- нээлтэд зориулсан илтгэ- но гарав.

НАЙРАМДЛЫН САР УГТАЖ...

Баян сумын харилцаа лүүлж сайхан амжилт гар- холбооны салбар Монгол- гав. Олоо тус салбарынхан Зөвлөлтийн найрамдлын 4 дүгээр улирлын төлөв- 23 дахь сарыг угтаж энэ лөгөөгөө давуулж биелүү- оны 3 дугаар улирлын тө- лөх зорилттой шамдан лөвлөгөөт үзүүлэлтүүдээ ажиллаж байна.

114,6—213 хувиар бие-

с. отгон

КОММУНИЗМ БИР ОДНУ

Н. ШАГДАРДАГВА

БНАГУ-ын 25 жилийн ойд

ӨНӨӨГИЙН СОЦИАЛИСТ ГЕРМАН

ЗХУ-ын баатарлаг улаан арми дэлхийн II дайнд түүхэн ялалт хийж, Европын улс түмнийг фашизмын боолчлолоос чөлөөлсний үр дүнд 1949 оны 10 дугаар сарын 7-нд Германы түүхэнд анхны амжилчин тариачны социалист улс—БНАГУ байгуулагдсан нь Германы ард түмний түүхэнд шинэ үеийг нээсэн юм.

Тэр үеэс эдүгээ хүртлэх хөгжил дэвшлийн 25 жилийн түүх нь хөгжингүй социалист нийгмийг амжилттай байгуулж байгаа өнөөгийн БНАГУ-ын бүтээн байгуулалтын гарамгай үйл явдлаар тодорхойлогдож байна.

Дэлхийн хамтын нөхөрлөлийн орнуудын салшгүй бүрэлдэхүүн хэсгийн нэг—БНАГУ одор дэл-

хийн аж үйлдвэрийн өндөр хөгжилтэй арваад орны нэг болтлоо хөгжин цэцэглэсэн юм.

Үндэсний орлого нь 1949 онд 25 тэрбум марк байсан бол одоо 127 тэрбумд хүрчээ. 1971 оноос хойш 330 мянган айлын орон сууц шинээр барьж, засварлан ашиглалтанд оруулсан ба 1975 онд 500 мянгад хүргэх зорилт тавьж орон сууцны барилга барих ажлыг орон даяар өрнүүлж, орчин үеийн шинэ шинэ хороолол сүндэрлэн босч байна.

1976—1990 он хүртлэх хугацаанд 2,8—3 сая айлын сууц шинээр барьж засварлан, сууцны асуудлыг бүрэн шийдвэрлэх ажээ. БНАГУ-д ноднингоос эхлэн хамтралыг хоршоолоход шилжин, хөдөө

аж ахуйг хөгжүүлэхэд шинэ томоохон алхам хийсэн байна. 1960 онд тариачид бүрэн хоршоолсноос хойш социалист хөдөө аж ахуй эрчимтэй хөгжиж одоо БНАГУ-д 770 мянган хоршоолсон тариачид, хөдөө аж ахуйн ардын үйлдвэрийн 92 мянган хөдөлмөрчид, хөдөө аж ахуйг механикжуулах, ХАА-н үйлдвэрлэлийг аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн аргад шилжүүлэх талаар үлэмж амжилт олж байна.

БНАГУ-д 1949 онд нэг га-гаас дунджаар 19,7 центнер ургац авч байсан бол 1973 онд 35,8 центнер хүрсэн ба энэ жил 43 центнерт хүргэх зорилттой ажиллажээ.

БНАГУ-д ХАА-н үйлдвэрлэлийг аж үйлдвэрийн

агсад шилжүүлэх ажлыг ХАА-н үйлдвэрлэлийн хоршоолол дундын газар тариалан эрхэлсэн нэгдлүүд байгуулах, шинжлэх ухаан техникийн тэргүүний ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх замаар шийдвэрлэж байна.

Одоо БНАГУ-д хоршоолол дундын нэгдлүүд 1200 ажиллаж тэр нь 4,4 сая га талбайд үйлдвэрлэл явуулж байна.

ХАА байнга мэргэжилтэй боловсон хүчээр хангагдаж байгаагийн үр дүнд одоо тус улсын ХАА-д ажиллагсдын 80 хувийг мэргэжилтэй, дипломтой хүмүүс эзлэх болжээ. Мөн БНАГУ-д социалист нийгмийн бүх талын боловсролтой шинэ хүнийг хууруулах, өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх талаар ихээхэн амжилт олж байна. Зөвхөн 1971—1973 онд

600 мянган залуус тусгай мэргэжил эзэмшиж, одоо их, дээд, тусгай мэргэжлийн сургуульд нийтдээ 180-аад мянган оюутан суралцаж байна.

ГНСН, БНАГУ-ын засгийн газрын энхтайванч тууштай гадаад бодлого нь БНАГУ-ын нэр хүндийг олон улсын тавцан дээр улам бэхжүүлж байгаа юм. Одоо БНАГУ, дэлхийн 100 гаруй оронтой дипломат харилцаатай дээр НҮБ болон түүний салбар олон улсын байгууллагуудад гишүүнээр элсэж тэдгээрийн үйл ажиллагаанд ямагт идэвхтэй оролцож байна.

Олон улсын коммунист амжилчны хөдөлгөөний дайчин отрядын нэг—ГНСН-ынхаа удирдлагаар Германы ард түмэн хөгжингүй социалист нийгэм байгуулах үйлтээ бахархам амжилт олсоор байна.

Б. ЦЭРЭНДАШ

ГЕРМАНЫ ЗАЛУУЧУУД

БНАГУ бол 17 сая хүн амтай, үйлдвэр их хөгжсөн социалист томоохон орон юм.

БНАГУ-ыг залуучуудын орон гэдэг байна.

Учир нь гэвэл ардчилсан Герман улсын хүн амын тэн хагасаас илүү хувийг 25 хүртлэх насны залуучууд эзэлнэ.

Германы Чөлөөт Залуучуудын Эвлэл нь Германы амжилчин ангийн хувсгалт эр эл хөгжмөлийн ялгуусан уламжлалыг өвлөн авч, өөрийн оронд шинэ амьдрал социализмыг амжилттай байгуулах их үйл хэрэгт идэвхтэй оролцож байна.

Одоо Германы Чөлөөт Залуучуудын Эвлэл эгнээндээ 1 сая 800 гаруй мянган хөвгүүд охидыг багтаажээ.

Германы залуучууд их үйлдвэрлэж, зөв хуваарилж сайхан амьдаръя гэ-

сэн уриалгыг гаргаж түүн э э амжилттай хэрэгжүүлж байна.

Германы залуучууд өөрсдийн хүчээр Германы нисэх онгоцны төв буудал, Шведдах нефтийн комбинат, Партендорфе дахь цахилгаан станц, Лейна II-химийн комбинат зэрэг олон арван байгууламжуудыг бүтээн босгожээ.

Германы Чөлөөт Залуучуудын Эвлэл залуучуудыг ертөнцийг үзэх Марксист-Ленинист үзлээр хүмүүжүүлэх үндсэн зорилтыг өөрийн үзэл суртал үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлж байна.

Л. БАТСУХ

(Лүн сумын ХЗЭ-ийн хорооны нарийн бичгийн дарга, дэлхийн залуучууд оюутны X их наадмын тоолоогч)

Өвлийн бэлтгэл зуун задгай

(Хамтын үзлэг)

Хүйтний улиралд үйлдвэрлэл, үйлчилгээ албан газар хэвийн ажиллагааг тогтвортой явуулах нь өвлийн бэлтгэлээс ихээхэн шалтгаална.

Гэтэл Зуунмод хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, Намын хороо хотын албан газруудын өвлийн бэлтгэлийг урин дулаанд хангуулах арга хэмжээ төдий л аваагүй өдий хүрчээ.

Иймээс тус хотын 14 уурын зуух орой галлагдсаны дотор зарим зуухны засвар одоо болтол дуусаагүйгээс албан байгууллага, хөдөлмөрчдийг хохируулж байхад НААҮГ-ын удирдах нөхдөд санаа амарлингуй сууж байна.

Нэгдсэн Больницын уурын зуух 10 дугаар сарын арвад хүртэл галлаагүй байгаа шалтгааныг НААҮГ-ын дарга Нацагдоржоос лавлахад хариуц-

гаар шилжүүлэх зэргээр ашиглалтанд оруулах хугацааг нь арав гаруй хоногоор саатуулан эмнэлэг үйлчилгээний ажлыг хүндрүүлжээ. Энэ байдлаас болж нэгдсэн больницад хэвтэж байгаа өвчтнүүд халаалт ирээгүй хүйтэн байранд тохь алдаж байна.

НААҮГ өнөө жил уурын зуух зургаад их ба урсгал засвар хийсэн гэх боловч газар дээр нь шалгаж үзэхэд зарим зуухны тааз нь нурж, ус шавар гоожин галлах нь байтугай дотор гаднах засвар нь зуун задгай байгаагийн дээр бүх зуухны галч нарын байрны тохижилт муу, слесарь, механикч нарт түлхүүр багаж дутагдалтай, хянаж шалгах багаж олонх зууханд тавиагүй, тэр ч байтугай одоо 24 галч дутуу байхад түүнийг гүйцээж ажиллуулах талаар огтхон санаа тавиагүй байна.

НААҮГ энэ жил засвар хийх төсөвтэй гутал, төмрийн тасаг, угаалгын цехийн барилгын засварыг хүч хүрэхгүй байна гэдгээр орхиод харин өнгөрсөн жил олон мянган төгрөг зарж зассан дарга, орлогч нарын өрөөг одоо дахин засч илүү зардал гаргажээ. Ингэж НААҮГ-ын ажиллагаанд зарчимч илбардлага, хяналт шалгалт, тооцоо судалгаа сулаас амжилчин, амжилтын хувийн хариуцлага сахилга бат суларч ажлыг оромдон орхиод явдал газар авч байна.

Барилга угсралтын контор энэ оны II улиралд хүлээлгэн өгөх ёстой УААҮГ-ын уурын зуух мөн гараагийн барилгын гадна холболтын ажлыг

одоо болтол дуусаагүйн дээр намын кабинетын барилгын суурийн ажил хийхдээ тасалсан ҮЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хороо, ЦС хэлтсийн дулааны холболтыг эхлүүлээгүйгээс эдгээр байгууллагууд ажил явуулах нөхцөлгүйд хүрч байна.

Мөн төвийн 10 жилийн дунд сургууль засварлах ёстой хүүхдийн дотуур байрны барилга засварыг хийгээгүйгээс уг барилгын доод давхарын тааз хөтөж, дээд давхарын 6 өрөөний шал 5—8 см хойтон хүүхэд суух боломжгүй болсон байхад ямарч арга хэмжээ аваагүй байгаа нь зүйд нийцэхгүй.

Эрчим хүчний салбар шугам сүлжээний ажлыг найдвартай хэвийн байлгаж чадахгүй байгаа дутагдал энэ жил давтсаар байна.


Нэгдэл дундын үйлдвэр энэ жил мөн л халаалтынхаа системд олготой засвар хийсэнгүй.

Үйлдвэр, аж ахуйн газруудын өвлийн бэлтгэл ийнхүү зуун задгай жагран хагархай байхад хотын Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа дорвитой арга хэмжээ авалгүй цаг алдаж байгаадаа дүгнэлт хийж, уг асуудлыг нам, улсын хариуцлага, сахилга баттай холбон үзэж яаралтай арга хэмжээ авах хэрэгтэй.

«Үнэн» сонинны тусгай сурвалжлагч О.СҮМБЯА

Хөдөлмөр хамгааллын улсын байцаагч Ш. БАТЛУЛГА

«Анхдугаар таван жил» сонинны тусгай сурвалжлагч Ш. ЦЭРЭНДОО



Сансрын уудмыг энх тайвны зорилгод ашиглах, судлах талаар социалист орнуудын хамтын ажиллагааны программын дагуу ЗХУ дэлхийн хиймэл дагуул «Интеркосмос—10»-ыг хооргов.

Дагуулд ЗХУ, БНАГУ, Чехословакийн мэргэжилтнүүдийн бүтээсэн эрдэм шинжилгээний багаж хэрэгсэлүүд тавигджээ.

Зураг дээр:

«Интеркосмос—10» дагуулыг пуужин зоогчид угсрахын өмнө.

ТАСС-ын гэрэл зураг.

ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН ЗОРИЛТ

Улсыг батлан хамгаалах арга хэмжээний салшгүй хэсэг иргэний хамгаалалтын арга хэмжээ нь тус улсын бүх нутаг дэвсгэр улс, олон нийтийн болон үйлдвэр, ХАА-н бүх байгууллагыг хамран зохион байгуулагдана. Засаг захиргааны нэгж, үйлдвэр, албан байгууллагын дарга нар нь иргэний хамгаалалтын дарга бөгөөд иргэний хамгаалалтын удирдлагыг тэдгээрт төвлөрүүлж дэргэд нь иргэний хамгаалалтын штаб байгуулж ажилладаг юм.

Штаб бол иргэний хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулж удирдах төв болно.

Хүн ам, хүнс тэжээл, мал, ус, ургамал хамгаалах арга хэмжээг төвлөж хэрэгжүүлэх, иргэний хамгаалалтын хүч хэрэгслийг зохион байгуулж бэлтгэн зохицуулж ажиллахын тулд аймаг, хотуудад төрөл бүрийн алба-дуг яам, тусгай газрын харьяа орон нутаг дахь байгууллагуудыг түшиглэн байгуулж ажилладаг.

Иргэний хамгаалалт нь тус улсын хүн хүч, материал нөөцөд тулгуурласан бүх нийтийн чанартай батлан хамгаалах арга хэмжээний систем юм. Иймээс иргэний хамгаалалтын үйл ажиллагааны хүрээ хэмжээ түүний нийгмийн үүрэг ач холбогдол үлэмж их юм.

Үйл олноор хөнөөн сүйтгэх зэвсэг болон довтолгооны бусад хэрэгслээс хүн амыг хамгаалахын тулд бүх нийтийг хамгаалалтын аргад сургаж, улс ардын аж ахуйг тогтвортой ажиллах нөхцөлөөр хангах арга хэмжээнүүдийг авч хөнөөлийн голомтод аврах, хойшлуулшгүй сөргөөн босгох ажил зохион явуулах хүч хэрэгслийг бэлтгэж шаардлагатай

үед ашиглахад байнга бэлэн байлгахад иргэний хамгаалалтын гол зорилт оршино.

Иргэний хамгаалалтын бат найдвартай удирдлагын системийг зохион байгуулснаар аюулын тухай зарлан мэдээлэх ба үйл олноор хөнөөн сүйтгэх зэвсэг болон довтолгооны бусад хэрэгслээс хүн амыг хамгаалах, дайны үед нэрвэгдсэн хүн амд тусламж үзүүлэн усны эх булаг, хүнс тэжээл, түүхий эд, мал, ургамал, тэжээл бордоог цацраг идэвхит бодис, химийн хордлого, бактери халдвараас хамгаалах, түүний хор уршгийг арилгах арга хэмжээг авах шаардлагатай. Иргэний хамгаалалтын эл бүх арга хэмжээг хэрэгжүүлэх нь хүн ам, үйлдвэрлэх хүчин, эдийн засгийн хамгаалах гол зорилготой юм.

Хүн амыг хамгаалахдаа

томоохон хот суурингаас нүүлгэн шилжүүлэх, ажилчин, албан хаагчдыг тараан байрлуулах, хүн нэг бүрийн болон нийтийг хамгаалах хэрэгслээр хангах арга хэмжээ авна.

Дайсны довтлох аюулын тухай цаг алдалгүй зарлан мэдээлэх радиц, хими биологийн хордолт, халдварын байдалд хяналт тавьж лабораторын шалгалт зохион байгуулан хүн амын дунд тайван үед ариун цэвэр эрүүл ахуйг сахин, халдварт өвчин эсэргүүцэх урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион явуулна.

Улс ардын аж ахуйн чухал объектууд, үйлдвэр, барилга, тээвэр, холбоо зэрэг салбарын тогтвортой ажиллагааг хангах явдлыг гагцхүү тайван үед бэлтгэнэ.

Үүний тулд хот суурин үйлдвэрийн ус цахилгаан дулааны хангамжийг найдвартай болгон үйлдвэрийн технологийн ажиллагааны барилга байгууламжийг

сайжруулан бэхжүүлэх, үйлдвэрийн ажилчин албан хаагчдад зориулж, хоргодох, далдлах байр байгуулах, хотын гаднах тараан байрлах байрыг тохижуулах зэрэг арга хэмжээг авах ёстой.

Мөн хөнөөлийн голомтод аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажил хийх мэргэжлийн ангиудыг сайн бэлтгэж сум-нэгдэл, САА, үйлдвэр, албан байгууллаага нэг бүрийг онцгой дэглэмд шилжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч явуулах бэлтгэлтэй болсон байх нь чухал.

Юуны өмнө мэргэжлийн ангиудыг тайван үед бэлтгэж байнгын бэлэн байдалд байлгах явдал онцгой ач холбогдолтой юм.

Иргэний хамгаалалтын хүч, бүрэлдэхүүнийг зохион байгуулж удирдах, сургаж бэлтгэхэд иргэний хамгаалалтын бүх шатны штаб, албадууд зохион байгуулалтын ажлын голыг чиглүүлэх, хэрэгтэй.

Р.ЛҮЙЖИР

Уннар дундаас сүүмэлзэх сүрлэг хөх уулсын наана цэлийн байх их талын дунд саяхан буусан бололтой цагаан гэр харагдахуйд хөлийн жолоо залав. Бадрахын булан, Эрдэнийн ам, ус бэлчээр тэгшхэн, чухам малын «диважин» болсон газар даа. Энд хэнийх нь оторлон ирж буугаад байдагсан билээ.

Ямарч боловч, малч эзэн тэй нь уулзаж отрын олзы нь сонирхъё гэж бодсоор тэднийд буухаар шийдэв. Тэрүүхэн гүдэн дээгүүр гартал сул асга сан сувд шиг хонин сүрэг налайн бэлчээрлэж, сүргийнхээ түрүүч талд хоньчин эр тухлан суух агаад морь нь эзнээ тойрон хаа нэгхэн толгой хайлаа.

Үүнийг харуут бид налайн бэлчээрлэсэн сүргий нь үргэж цочоохгүйн тулд машинаа холхон зогсоож хоньчин эртэй уулзлаа. За байз, энэ хүний чинь хаана үзлээ дээ.

Намхан нуруутай, монхордуу хамартай, тосон бор царайтай... Аа тийм, Ажваа баатар байна шүү дээ. Баатар ч нутгийн сайныг шилж малынхаа жаргалыг хөөж чаддаг хүн юм даа гэж бодох зуур мэнд мэдэлцээд за хэд дэх удаагийнхаа буудал дээр ирээд байгаа нь энэ билээ гэхэд намайг нилээд гайхсан байдалтай харснаа.

—16 дахь буудал. Энэ жил 700 охин төлөг харууцан маллаж байна даа.

Одоогийн байдлаар нэг төлөг дунджаар 46 кг таргаллаа. Энэ ч ус бэлчээр дагасны ашиг л даа.

Намрын отрыг сөл хөөл гэж олигтойхон хийх са-

наатай. Тэгээд төлөгөө 55 кг хүргэх зорилготой гэв. Энэ ч баатрын бодлог л санаа.

—Ноосны төлөвлөгөө юү болж байгаа билээ.

—Ноосыг манайхан «Цагаан алт» гэж ярьдаг. Аргагүй л манай үйлдвэрүүдийг хангадаг алт нь даа.

Ингэхээр ноосныхоо төлөвлөгөөг биелүүлэхгүй байна гэдэг чинь юү гэсэн үг вэ. Энэ жил үйлдвэрлэлийн даалгавраа 170 кг-аар давуулан төлөвлөгөөгөө 6 дугтар сарын 24-нд 122,2 хувиар биелүүлсэн. Энэ амжилт маань ноднигийнхтой харьцуулахад ахицтай юм.

МИНИЙ НЭР ҮҮ?

Н.Цэцэг

Ноднин 269 эр ямаа хариуцан маллаж ноолуурын 95 хувийг 1 дүгээр зэрэгт тушааж төлөвлөгөөнөөс 11 кг-аар давуулан ямаа нэг бүрээс 350 грамм ноолуур авч сумын аварга болсон. Харин уржсан 546 хонь нэг бүрээс дунджаар 1410 грамм ноос авч төлөвлөгөөг 113,3 хувиар биелүүлж 120 кг ноос давуулан сумын уржсан ноосны хошой аварга болсон юм.

Сүүлийн хэдэн жилийн амжилтыг энэ жил алдахгүй харин ахиулах санаатай шүү.

—Энэ ч баатрын бодлог л санаа. Ажваа гуайг би олон шавьтай хүн гэж хэдийнээ мэдэх болохоор шавь нарынх нь ажлын

амжилтаас сонирхмоор санагдлаа.

—Таны шавь нараас хэн нь түрүүлж явна даа гэхэд. Аа манай шавь нараас уу? Илгээлтийн эзэн Ү.Лхагвасүрэн 537 хоньтой, та нар танина биз дээ? Өнгөрсөн жил мэнд төлчин шалгаруулах уралдаанд түрүүлж ЗХУ-ын Москва, Ленинград, Иркутск хотуор жуулчилсан жаал бор хүү шүү дээ.


Бас А.Бямбаням, Ч.Бямбасүрэн, С.Нансалмаа гээд хэдэн бузгай хүүхдүүд биш. Энэ хэдэн хүүхдийг өөрийнхөө туршлагаар ажиллуулж амжилтанд хүргэх санаатай.

Энэ ч аргагүй баатрын бодлог санаа. Тэгээд тэр эр босч энэ буудал дээрээ 3—4 хоноод энүүхэн Эрдэнэрүү нутаг сэлгэнэ.

Нутаг сэлгээсээ өмнө сонгогчидтойгоо нэг уулзаад Алтанбулаг сумын хэд хөдөлмөрчдийн ойрын гүйцэтгэх зорилты нь таниулах бодолтой гээд олмоо чангаллаа. Ингэж ярихтай зэрэг Ажваа баатар Алтанбулаг суманд ажиллаж байгаа байх нь ээ гэж бодсоноо гэнэтхэн нэг сонин санаа сэтгэлд бууж, ингэхэд таны багш хэнсэн билээ гэж асуугаад, энэ тухай түүнийг маш сонирхолтой зүйл ярина гэж бодлоо.

Гэтэл миний багш... Ажваа гэлээ. Бй бүр учраа олохоо байж Ажваа баатрын багш бас Ажваа гэлэж сайн малчин байдаг байжээ гэж нэг эргэлзсэнээ, алдар хэнсэн билээ гэж өөрийн эрхгүй дуу алдлаа. Миний нэр үү? Дашээвэгийн Догсом гэлээ. Ийм адилхан багш шавь хоёр байх гэж...

Л.ХАНЧЯАХАВ



Барнаулийн онгоцны буудал дээр бүр нислэгийн сургуулийн онгоцны дуу чимээ үл тасарна. Барнаул хотын баглан хамгаалах сайн дурын нийгэмлэгийн агаарын спорт клубт албанбайгууллага, сургууль, үйлдвэрийн газрын олон зуун охид, хөвгүүд онгоц жолоодох болон шүүхрээр буух аргаг суралцаг. ЗУРАГ ДЭЭР: ЗХУ-ын спортын мастер Евгений Новиков шүүхрээр буухаар зэхэж байгаа нь.

ТААО-ын гэрэл зураг

АНЧДЫН НИЙГЭМЛЭГИЙН III БАГА ХУРАЛ

(Төгсгөл. Түрүүч нь II нүүрт)

гэмлэгийн зөвлөлийн даргаар нөхөр Х.Дамдин, шалган байцаах комиссын даргаар П.Пүрэвсүрэн нарыг, Монголын анчдын нийгэмлэгийн III их хуралд очих

төлөөлөгчдөөр 13 хүнийг санал нэгтэй батлав.

Бага хуралд БНМАУ-ын Анчдын Нийгэмлэгийн Төв Зөвлөлийн тэргүүлэгч гишүүн, Ой Модны Аж Үйлдвэрийн Яамны агнуур зүйч Л.Бидон оролцож үг хэллэв.

ТОВЧХОН

Угтаалын сангийн аж ахуйн хамт олон одоогийн байдлаар 4600 шахам гагийн тариаг ангиалан хадгаж, улсад тушаах тарианы төлөвлөгөөг 2,3 мянган тонноор давуулах

үүрэг авснаа биелүүлэх бүрэн бололцоо олж, га тутмаас 12,5—14 центнер ургац хурааж байна.

Тус САА-н комбайндын 70 гаруй хувь нь ургац хураах өдөр бүрийн нормоо давуулан биелүүлж байна.

С.ОТГОН

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ